



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/44

Зуунмод

Г Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл
цуцлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрдэнэ сумын нутагт “Эрдэнэ” нэртэй “Хан чулуу од плант” ХХК-ийн XV-41000189 (X23/001) тоот хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий 61,96 гектар талбайг бүхэлд нь буцаан өгөх тухай өргөдлийг үндэслэн “Эрдэнэ” нэртэй талбайг бүхэлд нь буцаан авсугай.

2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцалсан нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийг байгаль орчныг нөхөн сэргээх үүргээс чөлөөлөхгүй тул хөндөгдсөн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хуулийн хугацаанд мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэн орон нутагт хүлээлгэн өгөхийг “Хан чулуу од плант” ХХК-ийн захирал (Б.Одгэрэл)-д даалгасугай.

3.Захирамжийг холбогдох газруудад хүргүүлж мэдээллийн санд бүртгүүлэн хяналт тавьж, тус талбайг хүлээн авахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ), Хууль, эрх зүйн хэлтсийн Геологи, уул уурхай, газрын тос, хийн хяналтын Улсын байцаагч (Т.Мөнхжаргал), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Ж.Даш-яйчил), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Насанжаргал), Эрдэнэ сумын Засаг дарга (А.Мөнгөнбаяр) нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4124010114

My.Doc.zahiramj 2024-1 uliral